



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 154.

Улаанбаатар хот

Орон сууц хувьчлах товчоо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Орон сууц хувьчлах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Орон сууц хувьчлах товчооны ажиллах журмын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:



1. Увс аймгийн орон сууц хувьчлах товчоог хавсралтад заасан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.
2. Орон сууц хувьчлах тухай хууль тогтоомж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан "Орон сууц хувьчлах товчооны ажиллах журам"-ыг мөрдөж ажиллахыг товчоонд үүрэг болгосугай.
3. Товчооны үйл ажиллагааны зардлыг зохих журмын дагуу тооцож, төсөвт тусган санхүүжүүлэхийг Увс аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д зөвлөсүгэй.
4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2025 оны 04 дүгээр сарын 03-ны
өдрийн 154 дүгээр тогтоолын хавсралт

УВС АЙМГИЙН ОРОН СУУЦ ХУВЬЧЛАХ
ТОВЧООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Товчооны дарга

Аймгийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга

Аймгийн Засаг даргын эрхлэх
асуудлын хүрээний агентлаг Орон
нутгийн өмчийн газрын ахлах
мэргэжилтэн

Гишүүд

Аймгийн Засаг даргын Тамгын
газрын Санхүү, төрийн сангийн
хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын
газрын Хууль, эрхзүйн хэлтсийн
ахлах мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын Тамгын
газрын Бүс, орон нутгийн хөрөнгө
оруулалт, бодлого, төлөвлөлтийн
хэлтсийн ахлах мэргэжилтэн

.....ооо.....